
**АЖЛЫН БАЙРНЫ ЗАР** · 2025 оны 10-р сарын 21

# ПРОКУРОРЫН ТУСЛАХ АЖИЛТНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР




Прокурорын туслах ажилтны ажлын байранд ажиллах хүсэлтэй иргэдийн сонгон шалгаруулалтыг "Прокурорын байгууллагын захиргааны албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх журам"-ын дагуу зохион байгуулна.

**Нэг:** Тавигдах болзол, шаардлага

- Монгол Улсын иргэн байх;

- Хууль зүйн дээд боловсролтой байх;

- Гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцогдож байгаагүй;

- Хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн үүргээ биелүүлсэн байх;

- Төрийн албаны тухай хуулийн 46.2.2, 46.2.3-т заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөөгүй байх;

- Иргэний хувьд төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй байх;

- Энэ зарт тавигдсан "Прокурорын байгууллагын захиргааны албаны удирдах болон

гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх журам” болон шаардлага, зөвлөмжтэй танилцсан байх.

**Хоёр:** Бүрдүүлэх материал

- Төрийн албан хаагчийн анкет

- Шалгалтад оролцохыг хүссэн өргөдөл

- Шалгалтад оролцох иргэний 3 үеийн намтар

- Бакалавр, түүнээс дээш боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичгийн баталгаажуулсан хуулбар / гадаадын их сургууль төгссөн бол баталгаат орчуулга/

- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичгийн баталгаажуулсан хуулбар /төрийн албан хаагчид хамаарна/.

- Иргэний үнэмлэхний хуулбар

- Хөдөлмөр эрхлэлтийн байдлыг нотолсон баримт

- Цээж зураг  3 хувь / хэмжээ 4х6 см /

- Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй бол баталгаажуулсан хуулбар

- Төрийн албаны ерөнхий шалгалтын дүнгийн хуудас

- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангарагийн хуудас” хуулбар

- Цэргийн албыг биечилж болон дүйцүүлэн хаасныг гэрчлэх баримт бичгийн баталгаажуулсан хуулбар

- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа болон байсан эсэх тухай тодорхойлолтыг /E-mongolia-аас татан авах/

**Гурав:** Албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг хангаж байгаа албан хаагч, иргэдэд шалгалт өгөх, өдөр, цаг, байршил болон бусад мэдээллийг **prosecutor.mn** сайтаар мэдээлнэ.

**Дөрөв:** Оролцогчид дээрх материалыг бүрдүүлж, 2025 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 17:00 цаг хүртэл Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг Бага тойруу Хуульчдын гудамж 15/1 хаягаар илгээх, эсхүл Улсын ерөнхий прокурорын газрын 103 тоот өрөөнд биечлэн хүлээлгэн өгөх боломжтой.

*Бүртгэлийн хураамж 40.000 төгрөг*

*Холбоо барих утас: 88019466, 89990557*

---